

Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн

2018 оны 2 дугаар сарын 01-ээс 3 дугаар сарын 20 хүртэлх хугацаанд хийсэн ажлын тайлан

2018.03.23

Мэдээллийн сүлжээний найдвартай ажиллагааг хангах чиглэлээр

ДЦУБ-ын олон улсын сүлжээнээс хүлээн авах 448 хугацааны мэдээ, дотоодоос хүлээн авах 33480 мэдээг бүрэн хүлээн авч, боловсруулан, олон улсын болон дотоодын сүлжээнд гаргалаа.

Хиймэл дагуулын мэдээ хүлээн авах станцын Vxeos системийн үйл ажиллагаа хэвийн явагдаж, МОДИС/Aqua-Terra дагуулын 199, NPP дагуулын 93, NOAA дагуулын 67, G-Com дагуулын 190 мэдээг хүлээн авч боловсруулсан байна. CMA-CAST хүлээн авах системийн мэдээ хүлээн авалт хэвийн үргэлжилж, FY-2E дагуулын 722, FY-2G дагуулын 665, FY4A дагуулын 5378 файл мэдээг хүлээн авч, FY2G мэдээгээр үүлний боловсруулалтыг хийж, EWBMS системийн агаарын температур болон тунадасны зургийн боловсруулалтанд зориулан ХААЦУС хэлтэст өгсөн байна. Гаргаж байгаа бүтээгдэхүүн болон эх мэдээг хүрээлэнгийн цахим хуудсанд байршуулан олон нийтэд хүргэлээ. Хиймэл дагуулын мэдээний TDS каталог серверийн (<http://103.206.195.38:8080/thredds>) үйл ажиллагаа хэвийн, мэдээ бүрдүүлэлт сайн явагдаж байна.

Төв, орон нутгийн сүлжээний хурдыг нэмэгдүүлэх, шинэчлэх ажлын хүрээнд Өмнөговь, Говь-Алтай, Сүхбаатар, Дархан-Уул аймгуудын УЦУОШГазрууд сүлжээгээ шинэчлэн зохион байгуулж, Завхан, Ховд, Эрдэнэт, Хөвсгөл, Дорноговь, Сэлэнгэ, Булган аймгуудад шаардлагатай материалыг нэгдсэн байдлаар авч явуулсан бөгөөд ЦУОШГ-ын төв байрны дотоод сүлжээг сайжруулахад шаардлагатай материалыг захиалж, бэлтгэлийг хангаж байна. “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨК-тай хамтран аймгуудад интернетийн урсгалыг шинээр үүсгэх ажил хийгдэж байна. БОХЗТЛ-ийн дотоод сүлжээний кабелиудыг шинэчлэн, сүлжээний төхөөрөмжийг 1GB болгосноор сүлжээний хурдыг нэмэгдүүлж, 3 компьютерийн системийг шинэчилж, хэрэглээний програмуудыг суулгаж, хэвийн ажиллуулах арга хэмжээг авч ажиллав.

Машин заалны агааржуулалтын системд “Хөргөлт сервис”, “Сэрүүн сервис” ХХК-тай хамтран үзлэг үйлчилгээ, цэвэрлэгээг хийсэн бөгөөд 3 дугаар сарын 12-ноос эхлэн суперкомпьютерийн агааржуулалтын системд доголдол гарч, “Сэрүүн сервис” ХХК-ий инженерүүд шалгаж үзэхэд хөргөгч хий-фреоныг дамжуулах хоолой цоорсны улмаас хий алдагдсаныг тогтоож, гэмтлийг засварлав. Энэ хугацаанд суперкомпьютерийн ажиллагааг түр зогсоосон бөгөөд суперкомпьютерийн филтер болон санах ойн тусгаарлагч тосыг солих арга хэмжээг авлаа.

УБ хотын УЦУОШГ-ын APC1500 тог баригч, 203 тоот өрөөний сүлжээний төхөөрөмжийн тог баригчийн батареинуудыг солилоо.

Дархан-Уул аймгийн УЦУОШГ-ын сүлжээний инженер Алтаншагайг 2 өдөр дадлага хийлгэж, шинээр ажилд орж байгаа О.Наранбадрахад CMACAST дагуулын хүлээн авах систем болон дотоод сүлжээний талаар танилцуулж, дагалдууллаа.

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраас зохион байгуулсан “Цахим засаглал ба Мэдээллийн аюулгүй байдал” нээлттэй хэлэлцүүлэгт О.Энхцэцэг, Х.Болормаа нар оролцож, Авилгатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалтанд О.Энхцэцэг хамрагдав.

Цаг уур, уур амьсгалын судалгааны талаар

Цаг уурын 135 өртөө, 181 харуулын 2018 оны 1 дүгээр сарын цахим мэдээнд онолын шалгалтыг, уур амьсгалын үндсэн элементүүдийн хувьд орон зайн нарийвчилсан шалгалт хийж, ISX, RES, TAB хэлбэрээр нийт 948 нэгж мэдээг бэлтгэж, хадгалсан бөгөөд 2017 оны 11 дүгээр сарын мэдээг ЦУОШГ-ын Архив, мэдээллийн санд өгөв.

Нарны цацрагийн 2018 оны 1 дүгээр сарын мэдээг боловсруулан эмхэтгэлийг зохиож, ISX, TAB мэдээг үүсгэж, хадгалсан бөгөөд архивын мэдээг 2017 оныг дуустал хугацаагаар цувааг жигдрүүлж, мэдээллийн дэд санд оруулж, мэдээг архивт өглөө.

Аэрологийн Улаанбаатар, Мөрөн, Улаангом, Даланзадгад станцуудын 2018 оны 2 дугаар сарын радиозонд хөөргөлтийн мэдээг сүлжээгээр авч, тайланд шүүмж шалгалтыг хийж, архивлав.

Уур амьсгалын горимын мэдээний электрон дэд санг баяжуулах ажлын хүрээнд 1995-1998 оны 4 жилийн мэдээг шалгаж, хөрсний гүний температурын ажиглалттай 44 станцын ажиглалтын мэдээг байгуулагдсан хугацаанаас нь өнөөг хүртэлх хугацаагаар ЦУОШГ-ын Архив, мэдээллийн хэлтсээс авч, ажиглалтын цувааны нэгэн төрлийн байдалд шалгалт хийж, тасралтын талаарх бүртгэлийг хийлээ. Мөн нарны ажиглалтын болон аэрологийн мэдээний нэг төрлийн байдалд шалгалт хийж, цувааны тасралтын талаарх бүртгэлийг хийжээ.

Орон нутгийн салбаруудын анхан шатны ажиглалтын технологи мөрдөлтөд хяналт тавьж, 316 нэгж салбар/өртөө, харуул/-ын мэдээнд хяналтын шалгалт хийж, шалгалтаар илэрсэн алдаа, дутагдлын талаар зааварчлага бичиж, хүргүүлсэн. Нарны цацрагийн болон аэрологийн станцуудын 1 дүгээр сарын тайланд хариу зааварчлага бичиж, утсаар, сүлжээгээр зөвлөлгөө өгч ажиллалаа.

Өмнөговь аймгийн Даланзадгад аэрологийн станцын 2 дугаар сарын 5, 8, 11, 13-ны 20 цаг, 22-ны өглөөний 08 цагийн ажиглалтын температурын хэмжилт радиозондын температурын хүлээн авагчийн мэдрэх чадвараас хамааран алдаатай гарсан учир станцыг нийлүүлэгч БНХАУ-ын ӨМӨЗО-ны Цаг уурын газарт танилцуулахад гологдол радиозонд гарах тохиолдол тэнд ч мөн адил гарч байгаа гэсэн хариуг өгсөн байна.

“Арц Богдын өвөр хоолойн хүйтний улирлын их салхины гарал үүсэл, хамрах хүрээг тодорхойлох нь” сэдвээр суурь судалгааны төслийн саналыг бэлтгэж, “Аялал жуулчдад зориулсан уур амьсгалын цахим лавлах гаргаж, хэрэглэгчдэд хүргэх нь” төслийн саналыг Байгаль орчин, уур амьсгалын санд өгөөд байна.

Япон улсын Чуо их сургуультай хамтран хийж байгаа уур амьсгалын өөрчлөлтийн судалгааны ажлын хүрээнд хийгддэг нүүрсхүчлийн хий, метан, усны мониторингийн ажил хэвийн үргэлжилж, Нагояа их сургуультай хийж байгаа 4D төслийн тайланг явуулж, БНСУ-ын Цаг уурын агентлагтай хамтын ажиллагааны протоколын биелэлтийг гаргаж хүргүүллээ.

Улаанбаатар хотын УЦУОШГ-ын дарга А.Золзаяагийн хүсэлтээр Улаанбаатар аэрологийн өртөөний 2017 оны 8 дугаар сарын АХ-5 хэлбэрээр ирсэн тайлангийн эх хувиас хүснэгтийн дэлгэрэнгүйг гаргаж, өглөө.

2 дугаар сарын 19-22-нд Японы Цукубагийн их сургуулиас Тайланд улсын Азийн технологийн сургууль дээр зохион байгуулсан “Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийн үнэлгээ, дасан зохицох, хот төлөвлөлтийг S8*SI-CAT програмаар орон зайн нарийвчлалтай буулгах” практик сургалтад Д.Дуламсүрэн хамрагдаж, S8*SI-CAT програмын болон хийсэн дадлага ажлын үр дүнгийнхээ талаар хэлтсийн албан хаагчдад мэдээлэл хийжээ.

Өмнөговь аймгийн УЦУОШГ-ын аэрологийн инженер Түвшинбаярт радиозондын тайлан материалд шүүмж шалгалт хийх, орчих мандлын завсрын түвшнийг тодорхойлох талаар заавар, зөвлөмж өглөө.

Цаг агаар, орчны тоон загварчлал, судалгааны ажлын талаар

1 Мэдээлэл боловсруулалт, үйлчилгээ

Хүлэмжийн хийн ажиглалтын Улаан-Уул станцад 2 дугаар сард авсан агаарын дээжийг АНУ-ын Элчин сайдын яаманд дамжуулж, Даланзадгад, Сайншанд, Замын-Үүд, Улаанбаатар тоосны станцуудын 2018 оны 2 дугаар сарын тоосны мэдээгээр мэдээллийн санг баяжуулж, 2 дугаар сард ашигласан аргын тооцоо, тоон загваруудын бодолтыг бүртгэн, таарцыг дүгнэж, танилцуулсан байна.

MercuryCorps байгууллагатай хамтран цаг уурын станц, харуулаар гаргаж байгаа 5 хоногийн цаг агаарын урьдчилсан мэдээг гадаад хаягаар дамжуулах програм хангамжийн тохиргоог хийж, 1-ээс 5 хоног тус бүрд өдөр шөнөөр, 28 станцаар 2017 оны хамгийн сайн таарцтай хамгийн их температурын арга, загварууд, 2013-2017 онуудын хоорондох тунадас, салхины арга, загваруудын хамгийн сайн таарцтай аргуудыг тус тус гаргаж, prog maker програмд оруулахад бэлджээ.

Цаг агаарын тоон прогнозын далай, агаар мандлын Бусаны загварыг үйлдвэрлэлд дахин оруулж, гарсан үр дүнг зураг болгон сар, улирлын урьдчилсан мэдээ гаргахад ашиглах NCL-д суурилсан боловсруулалтын програмыг туршиж байна.

Шуурхай үйлчилгээний цахим хуудас, FTP /192.168.100.30/ серверүүдийн ажиллагаа болон цаг агаарын WRF, MM5, ADAM тоон загваруудын тасралтгүй ажиллагаа, цаг агаарын прогноз зураг, бодит зураг, хүснэгт мэдээний боловсруулалт, хадгалалтад тус тус хяналт тавьж, шуурхай үйлчилгээнд гарсан технологийн саатлын бүртгэл бүрэн хийгдэж байна.

2 Эрдэм шинжилгээ, судалгааны ажил

“Шороон шуурганы эрсдэл, эртнээс сэрэмжлүүлэх арга технологи боловсруулах эхний үе шатны судалгаа” сэдэвт ажлын хүрээнд тоос босох салхины босго утгыг 30%, 50%, 70%-ийн магадлалтай ажиглагдах прогнозын аргыг мэдээллийн серверт холболоо. Улаанбаатар хотын агаарын бохирдлын харуулуудын 2017 оны мэдээг боловсруулах, 2017 оны 12 дугаар сараас “Салхит” салхин цахилгаан станцад салхины эрчим хүчний 72 цагийн прогнозоор үйлчилж эхэлсэнтэй холбоотойгоор прогнозын үр дүнг бодит ажиглалтын мэдээтэй харьцуулан үр дүнг сайжруулах, Увс нуурын усны дулааны горимын талаар хийсэн хамтарсан судалгааны үр дүнг мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлэхээр бэлдэх, Сибирь болон Монголын томоохон нууруудын агаар мандлын хязгаарын үе давхаргад үзүүлэх нөлөөг судлахаар тоон загварын туршилтыг хийх, агаарын бохирдлын CMAQ загварыг суперкомпьютерт суулгах, турших, өвлийн улирлын урьдчилсан мэдээ гаргах арга зүйн үйлдвэрлэлийн туршилтыг хийх зэрэг ажлууд хийгдэж байна. “Магадлалт тунадасны прогноз” сэдэвт ажлын хүрээнд ECMWF-ийн 2002-2017 оны реанализын болон прогноз мэдээнээс газрын гадаргын даралт, 500гПа-ийн геопотенциал өндөр, 850гПа-ын температурын бүтээгдэхүүнээс төсөөтэй орон хайж, корреляцийн коэффициент нь 0.7-оос дээш хамааралтай болон 0.7-оос дээш хамааралтай цувааны тоо 100-аас бага бол хамгийн сайн хамааралтай 100 цуваанаас магадлалыг тооцоолон гаргах, прогнозыг шөнө, өдрөөр нь 144 цаг хүртэл урьдчилалтайгаар магадлан бүх станц харуулаар гаргахаар системийн тохируулгыг хийж, туршилтын бодолтуудыг эхлээд байна.

ЦУОШГ, БНСУ-ын Цаг уурын газрын хооронд цаг уурын салбарт хамтран ажиллах 7 дугаар уулзалтын протоколын 5.1 ба 5.2 заалтын дагуу Өмнөговийн Номгон, Дорноговийн Эрдэнэ суман дахь цамхагийн болон тоосны багаж тоног төхөөрөмжийн ажиллагаанд хяналт тавьж, Японы улсын Тоттори их сургуулийн Гандуу-хуурай газрын судалгааны төвтэй хамтран хийж байгаа шороон шуурганы хэмжилт, судалгааны ажил Төв аймгийн Баян-Өнжүүл, Өмнөговь аймгийн Цогт-Овоо сумдад хэвийн үргэлжилж байна. Япон улсын Нагояа Их сургуультай хамтран хэрэгжүүлж байгаа “4D” төслийн хүрээнд NCEP Climate Forecast System (CFSv2)-ийн 1982-2017 оны мэдээг ашиглан Монгол орны хэмжээгээр температур, тунадас, салхины хурд болон цасны зузааны 10 хоногийн аномалийн прогноз гаргах технологийг боловсруулж, гарсан үр дүнг ECMWF-ийн реанализ мэдээтэй харьцуулснаар сар бүрийн 23-нд дараа сарын прогнозыг гаргаж байхаар үйлдвэрлэлд ашиглахад бэлэн боллоо.

2 дугаар сарын 17-22-ны өдрүүдэд Тайландын Азийн Технологийн Дээд Сургууль дээр “Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулахад газар ашиглалтын мэдээллийг ашиглах нь” сэдэвт сургалтанд Д.Одонтунгалаг хамрагдаж, хэлтсийн албан хаагчдад тайлагналаа.

Байгаль орчны мэдээллийн сангийн үйл ажиллагааны талаар

Улсын статистикийн 2017 оны мэдээ бүрдүүлэлтийн явцын талаарх мэдээлэл болон ҮСХ-оос боловсруулсан Материалын урсгалын дансыг байгуулах аргачлалд өгөх саналыг БОАЖЯ-ны мэргэжилтэн Одбаярт 3 дугаар сарын 19-нд өгөв.

1. Байгаль орчны мэдээллийн сан байгуулах, хөгжүүлэх

БОАЖЯ-аас ирүүлсэн саналыг ТХГН-ийн газар ашиглалтын сангийн өгөгдлийн толь бичигт тусган шинэчилж, мэдээлийн сангийн загварыг гаргалаа.

2. Байгаль орчны мэдээллийн санд дараах мэдээг оруулж, үйлчилгээг үзүүлэв.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэдээллийн санд нарийвчилсан үнэлгээний 6 тайлан орж, 3 компанид мэдээ оруулах талаар хичээл оров. Байгууллага, хүний нөөцийн санд 81, агаарын бохирдлын санд 2018 оны 2 дугаар сарын 233 мэдээг тус тус оруулж, хууль эрх зүйн мэдээллийн санд Засгийн газрын тогтоол 1, Сайдын тушаал 3-ыг шинээр нэмж, хүчингүй болсон 1 тушаалын статусыг шинэчилсэн байна.

Хог хаягдлын сангийн хогийн төвлөрсөн цэгийн мэдээ оруулах хүснэгтийн өгөгдлийн толь бичиг болон загварыг шинэчилжээ.

Байгаль орчны мэдээллийн сангийн www.eic.mn серверийн файлын нөөцлөлтийг 2018 оны 3 дугаар сарын 12-ны байдлаар хийж, хүрээлэнгийн цахим хуудсанд 2 дугаар сарын үйл ажиллагааны тайланг оруулж, гадаргын усны мэдээллийн сангаас гадаргын усны зураг, орчны доройтол, бохирдлын сангаас бохирдлын судалгаа хийгдсэн газрын байршил, гео-мэдээллийн сангаас хур тунадасны жилийн дундаж хэмжээг тус тус share форматаар гаргаж, үйлчлэв.

Усны нөөцийн нэгдсэн менежментийн Момо төслийн мэдээллийн санд хандах 10 хэрэглэгчийн хүсэлтийг хүлээн авч, Хараа-Ерөө голын сав газрын атласад хандах эрхийг нээж өгөв.

Хамтын ажиллагааны хүрээнд Английн Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэг(ZSL)-тэй хамтран хийж байгаа “Зэрлэг амьтан, ургамлын хууль бус худалдаа, ан агнуурын гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийн сан байгуулах” ажлын хүрээнд мэдээллийн санг хөгжүүлэх ажил бүрэн дуусч, серверт www.eic.mn хаягаар байршуулжээ. ГЕГ, МХЕГ-аас амьтан, ургамлын хууль бус худалдаа, ан агнуурын гэмт хэрэг, зөрчлийн мэдээ ирүүлсэн бөгөөд МХЕГ-аас ирүүлсэн мэдээг мэдээллийн

санд оруулах ажил үргэлжилж, тайлангийн хугацаанд амьтны 2013 оны 2, 2014 оны 2, 2015 оны 4, 2016 оны 3, 2017 оны 20, 2018 оны 1 мэдээ, ГЕГ-аас ирүүлсэн мэдээнээс амьтны 2014 оны 1, 2015 оны 20, 2016 оны 30, 2017 оны 10 мэдээ, ургамлын 2011 оны 1, 2014 оны 1, 2015 оны 14, 2016 оны 7, 2017 оны 13 мэдээ, ЦЕГ-ын Мэдээлэл нэгтгэн боловсруулах газраас ирүүлсэн мэдээнээс амьтны 2015 оны 38, 2016 оны 27, 2017 оны 37 мэдээ, ургамлын 2015 оны 6, 2016 оны 4, 2017 оны 1 мэдээг тус тус мэдээллийн санд оруулж, ГЕГ-аас ирүүлсэн зүйлийн нэр тодорхойгүй 9 мэдээ, ЦЕГ-аас ирүүлсэн амьтны нэр тодорхойгүй 17 мэдээ тус тус мэдээллийн санд орсонгүй.

Мэдээллийн сангийн хэрэглэгчийн гарын авлагыг товч /32 хуудас/ болон дэлгэрэнгүй /82 хуудас/ хэлбэрээр бэлтгэж, 3 дугаар сарын 15-нд ZSL-ээс зохион байгуулсан “Байгалийн нөөцийг тогтвортой ашиглах нь” сэдэвт сургагч багш бэлтгэх сургалтад уг мэдээллийн сангийн талаар танилцуулга хийв.

UNREDD+ хөтөлбөртэй хэрэгжүүлсэн төслийн үр дүнгээр бий болсон Ойн мэдээллийн санг англи хэл рүү хөрвүүлэх ажил үргэлжилж, ажлын явцын тайланг UN-REDD-ийн олон улсын зөвлөхөд явуулж, ойн нөөцийн(13 хуудас), ойн нөхөн сэргээлтийн(83 хуудас), ойн ашиглалт, зөвшөөрөл, зөрчлийн мэдээллийн сангийн (30 хуудас), ой, хээрийн гал түймрийн мэдээллийн сангийн (26 хуудас) өгөгдлийн толь бичгийн орчуулгыг хүлээн авч, хяналаа. Ойн нөөц, ойн зохион байгуулалтын мэдээллийн сангийн интерфэйсийг англи хэл рүү хөрвүүлэх ажлыг бүрэн дуусч, www.eic.mn хаягаар байршуулж, ойн түймэр, ойн ашиглалт, зөвшөөрөл, зөрчлийн газарзүйн мэдээллийн интерфэйсийг англи хэл рүү хөрвүүлэх програм хөгжүүлэлтийн ажил дуусч, ойн хөнөөлт шавж, өвчний сан 40%, ойн нөхөн сэргээлтийн сангийн орчуулга 70%-ийн гүйцэтгэлтэй явагдаж байна.

Уул, уурхайн яамны төслөөс 3 дугаар сарын 6-16-нд зохион байгуулсан “Веб орчны програмчлал”-ын сургалтанд А.Батчимэг хамрагдлаа.

Зайнаас тандан судлалын чиглэлээр

Тайлангийн хугацаанд MODIS хиймэл дагуулын 202, SOUMI NPP дагуулын 98 мэдээг өөрийн архивд авсан ба 300 гаруй мэдээний архивын нөөцийг бэлтгэсэн байна. 2017 онд хийсэн түймэр, цасан бүрхэц, газрын гадаргын температурын сэдэвчилсэн мэдээнүүд, NASA-ийн NDVI/EVI мэдээний архивыг хийлээ.

Цасан бүрхэцийн 3, газрын гадаргын температурын 3, ой хээрийн түймрийн 3 зургийг тус тус боловсруулан гаргаж, хүрээлэнгийн www.icc.mn цахим хуудсанд байршуулж, Гамшгийн мэдээллийн санд оруулсан байна.

Гадаргын ус судлалын хэлтэст шар усны үерийн урьдчилсан мэдээ гаргахад зориулж, Туул голын сав газраарх цасны зургийг цасан бүрхэцийн талбайн тооцоололтойгоор, бусад 28 сав газраар цасан бүрхэцийн зураг хийж өгсөн байна.

АНДНЭЗК-ийн санхүүжилтээр хийж байгаа гэрээт ажлын хүрээнд “Гангийн мониторинг” систем дээр ажиллах гарын авлагыг орчуулж, нийт 61 хуудас бүхий гарын авлагыг монгол, англи хэл дээр хэвлүүлэхэд бэлдэж, хөндлөнгийн шинжээчийн хүсэлтийн дагуу 2017 онд газрын ажиглалтын 1500 цэг дээр хэмжигдсэн биомассын мэдээ болон цаг уурын станцын мэдээгээр тооцоолсон хур тунадасны стандартчилагдсан индексийн мэдээнүүдийг газарзүйн мэдээллийн системд оруулж, орон зайн зураглалыг хийж байгаа бөгөөд 4 дүгээр сарын 20-нд дотоодын оролцогч болон холбогдох байгууллагуудыг хамарсан хурал зохион байгуулах бэлтгэлийг хангаж байна.

ИБУИНВУ-ын Сансрын Агентлагтай эхлүүлж буй хамтын ажиллагааны хүрээнд 3 дугаар сарын 2-7-нд хоёр талын уулзалт холбогдох байгууллагууд, компаниудын түвшинд амжилттай хийгдлээ.

Хөдөө аж ахуйн цаг уурын ажлын талаар

Энэ сард давхардсан тоогоор нийт 954 салбарын агро дундаж мэдээг хүлээн авч, мэдээний чанар 99.89%-тай боловсруулалтанд орсон байна. 2018 оны 2 дугаар сарын 3 арав хоногийн тойм/Дугаар 4, 5, 6/-ыг арав хоногийн цаг агаарын нөхцлийн онцлогууд, 2 дугаар сарын цаг агаарын нөхцлийн тойм /III арав хоногт/, мал төллөх үеийн зөвлөмж, зудын эрсдэлийн зураг, мэдээлэл (1 дүгээр сарын 10-ны байдлаар) зэрэг мэдээ, мэдээллийг оруулан, хугацаанд нь гаргаж, www.tsag-aqaar.gov.mn цахим хуудсанд байршуулан үйлчилсэн бөгөөд электрон хэлбэрээр бүх аймгуудад хүргүүлжээ. 2018 оны өвлийн бэлчээрийн явуул судалгааны мэдээг хүлээн авч, цэгцлэн санд татаж байна

1 дүгээр сарын агродундаж мэдээний чанарын дүнг аймгуудад мэдээлж, 2 дугаар сарын 12-нд ТВ-9, 28-нд Монгол-HD телевизүүдэд өвөлжилтийн байдал, цас зудын талаарх мэдээг өглөө.

Сэлэнгэ, Төв, Говьсүмбэр, Булган аймгуудын хөдөө аж ахуйн цаг уурын ажиглалтын 2017 оны ХД-8 дэвтрүүд, Булган, Дорноговь, Төв аймгийн мал аж ахуйн цаг уурын ажиглалтын ХД-3 дэвтрүүдэд шүүмж шалгалтыг хийж, сангийн мэдээтэй тулган, хариу зааварчлагыг аймгуудад хүргүүлжээ.

Дархан-Уул аймгийн агро цаг уурын 2016, 2017 онуудын тайланд шүүмж хийж хүргүүлсэн бөгөөд Булган, Төв, Дорноговь аймгийн МААЦУ-ын 2016 оны шинжилгээний ажлын тайланг ШУТЗ-өөр хэлэлцүүлэхэд бэлтгэж байна.

Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын хүрээнд “Гүүний үйл хөдлөл, айрагны судалгаа”, “Бэлчээрийн ургамлын ургацыг гангийн индекстэй харьцуулан судлах нь” судалгааны ажлууд үргэлжилж, “SMAP хиймэл дагуулын мэдээг ашиглах боломж, түүнийг газрын мэдээгээр баталгаажуулан үнэлэх нь” ажлын хүрээнд эх мэдээний цувааг сунгахаар 2015 оны 3 дугаар сараас 2016 оны 11 дүгээр сар хүртэлх хугацааны мэдээг интернэтээс татаж, салхиар хөрс элэгдэх болон хөрснөөс шороо, тоос дэгдэхэд ургамал бүрхэвчийн нөлөөллийг үнэлэх зорилгоор 2000-2016 оны хаврын болон зуншлагын нөхцлийг хөдөө аж ахуйн цаг уурын индекс болон хиймэл дагуулын мэдээг ашиглан гантай, хэвийн, сайн зуншлагатай гэж ялган үнэлэх ажлыг хийж, бэлчээрийн болон таримал ургамлын өвчин, хөнөөлт шавьж, мэрэгчдийн 2017 оны мэдээгээр жилийн эмхэтгэлийг гаргаж, танилцуулах, санал зөвлөмжийн дагуу засварлах, бэлчээрийн ургамлын ургац, бүрхэцийн мэдээг нөхөх, норм гаргах, шалгуур шинжүүр утга тогтоох, бэлчээрийн ургамлын өндрийн мэдээнд анализ хийх зэрэг судалгааны ажлуудыг хийжээ.

2 дугаар сарын 23-нд болсон Төв аймгийн МААЦУ-ын харуулуудын шалган туслах ажлын дүнг хэлэлцэх ЦУОШГ-ын Даргын зөвлөлийн өргөтгөсөн хуралд Б.Эрдэнэцэцэг, Г.Раднаа нар оролцлоо.

Монгол орны бэлчээрийн үндэсний тайланг шинэчлэн гаргах ажлын хүрээнд тайлангийн эхний хувилбарыг хэлэлцэх уулзалтыг “Ногоон алт” төслийн судлаачидтай хийлээ. “Уур амьсгал болон газар ашиглалтын бэлчээрт үзүүлэх нөлөө” сэдэвт богино хугацааны сургалтанд бэлтгэж, хөтөлбөрийг нарийвчлан гаргаад байна.

Ус судлалын ажлын талаар

Ус судлалын 114 голын харуулын усны түвшин, мөсний үзэгдэл, зузааны мэдээг хүлээн авч, гар утас болон хүрээлэнгийн цахим хуудасны мэдээг шинэчлэв. Өнгөрөлт хэмжих 134 харуулаас ёроолдож хөлдсөн гол 61 байгаа ба бусад 75 харуулын 8 нь өнгөрөлт хэмжих чиглэлд тогтмол устай, сарын сүүлээр ёроолдож хөлдсөн болон хурд хэмжүүрийг сарын 20–ноос шалгалтанд оруулахаар татан авсан учир хэмжвэл зохих өнгөрөлтөөс 35 өнгөрөлтийг дутуу хэмжив. Булган өртөөний Ачуут-Булган харуул 2 дугаар сарын 11-нд ирүүлсэн алдаатай мэдээгээ засаагүй, Өвөрхангай өртөөний Зэгст-Өлзийт харуул 2 дугаар сарын 01-ний мэдээг тасалсан байна.

Мөс цөмрөх аюулаас сэрэмжлүүлэх мэдээг 4 удаа, Хөвсгөл нуурын мөсний зузааны талаарх тойм мэдээг тус тус гаргаж, хүрээлэнгийн цахим хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр дамжуулан ард иргэдэд үйлчлэв.

2016 оны урсацын эмхэтгэлд урсац бодсон аргын үнэлгээ УХ-10 хүснэгтийн түүврийг 136 харуулаар, мөсний үзэгдлийн түүврийг 152 харуулаар тус тус нэгтгэн оруулж, 135 станцын хур тунадас, 136 харуулын хангамшил, харуулын тодорхойлолт, 8 харуулын булингар, 40 цооног, 17 булаг, цэвдгийн болон мөстлийн эх мэдээг бэлтгэн оруулж, хэвлэв.

2016 оноор шар усны үерийн түүврийг 75 харуулаар, мөсний зузааны түүврийг 30 харуулаар, газрын доорхи усны түүврийг тус тус хийжээ.

Усны горим, үертэй холбоотой лавлагаа, мэдээллийг яам, агентлаг, хэвлэл мэдээллийнхэн болон бусад байгууллага, хувь хүнд тухай бүрийд нь гаргаж үйлчилсэн ба Хөгшин-Орхон-Хархорин харуулын талбай, харуулаас голын адаг хүртэлх голын уртыг тодорхойлж, тодорхойлолтыг БОАЖЯ-нд, Туул голын усны биологийн мэдээгээр хамгийн их бохирдолтой жил, сарыг гаргаж, дүнг Төв аймгийн УЦУОШГ-т тус тус хүргүүллээ.

ОХУ-ын холбогдох мэргэжилтэнтэй холбогдож, Река-режим програм хангамжийн сургалтын агуулга, хугацаа, хөтөлбөрийн талаар санал солилцож, бэлтгэлийг хангаж байна.

Landsat-L8 OLI/TRIS хиймэл дагуулын 2017 оны мэдээгээр 200 гаруй нуурын дүрс зүйг тодорхойлж, 50 гаруй мэдээг татаж, 42 уулын мөстлийн талбайг 2017 оны байдлаар тодорхойлох ажлын хүрээнд Асгатын даваа, Их Түргэн, Түргэн, Хатуугийн мөнх цаст, Мөнхцагаан цаст, Нарийн гол, Нортын нуруу, Цэнгэл Хайрхан, Цамбагарав уулсын талбай, периметрийг тодорхойлов.

Цөмийн Энергийн комисс болон хүрээлэнгийн удирдлагын уулзалтаар хамтран ажиллах талаар санал бодлоо солилцсоны дагуу изотопын техникийг уур амьсгалын өөрчлөлт, мөстөл, усны тэнцлийн судалгаанд ашиглах чиглэлээр хамтран ажиллах болон ШУТ-ийн төсөл боловсруулан хүргүүлээд байна.

Тайланг нэгтгэсэн

Ц.Батцэцэг